

Уран сайхны эхэд өгүүлэгчийн үнэлэмж дүрслэлт чимэг тодотголоор илрэх нь ("Байгаль ертөнц" гэсэн цогц ойлголт (концепц)-ын жишээн дээр)

Б.Мөнхтуяа*

МУБИС, Архангайн Багийн сургууль, хүмүүнлэгийн ухааны тэнхим

Хураангуй

Өгүүлэгчийн үнэлэмжийг уран дүрслэлийн найруулга бүхий эх дэх дүрслэлийн хэв маягтай холбон тайлбарлах боломж бий. Дүрслэлт чимэг тодотгол нь дүр дүрслэлийг тодруулах үүрэгтэйгээс гадна үндэстний өгүүлэгчийн эерэг үнэлэмж, үндэстний аж байдал, соёл болоод оюун санааны өвөрмөц онцлогуудыг багтаасан хэлний нэгж юм.

Дүрслэлт чимэг тодотголоор илрэх өгүүлэгчийн үнэлэмжийг "Байгаль" гэсэн цогц ойлголтын хүрээнд уран дүрслэлийн эхийн найруулгын жишээн дээр авч үзэх боломж байна.

Өгүүлэгчийн эерэг үнэлэмж нь нүүдлийн соёл иргэншилд байгаль дэлхийг хайрлаж, бишрэх, шүтэх, тахиж; уламжлалт зан заншил; хүндлэл бишрэл болоод туйлын хүсэл эрмэлзлэл; аж байдал, ахуй; жилийн 4 улиралд өргөн уудам газар нутагт нүүдэллэн амьдрах соёлын амьдрал зэрэгтэй холбоотой юм.

Түлхүүр үг

Метафор, өгүүлэгчийн үнэлэмж, чимэг тодотгол

Удиртгал

Эрдэмтэн О.С.Ахманова (1966, х.30): "Үнэлэмж (оценка-evaluation) нь өгүүлэгчийн бодол эрэгцүүлэл, түүнийг сайшаан зөвших ба үл сайшаан, үл ойшоосон үзэл, хандлага. Мөн энэ нь найруулгазүйн үндсэн хэсгийн нэг юм. Үнэлэмж нь: чанарын үнэлэмж (оценка качественная), найруулга зүйн үнэлэмж (оценка стилистическая), хувь хүний үнэлэмж (оценка субъективная), гоо зүйн үнэлэмж (оценка экспрессивно-модальная), сэтгэл хөдлөлийн үнэлэмж (оценка экспрессивно-эмоциональная), гэж ангилсан бол эрдэмтэн эрдэмтэн Н.Д.Арутюнова, Е.М. Вольф нар "Ерөнхий ба тусгай үнэлэмжийн хэлбэрүүд байна" гээд тусгай үнэлэмжийг (частооценочные) сэтгэл хөдлөл, гоо зүй, ёс зүй, тоо хэмжээ, өнгөний" (2004.х.269) гэх зэргээр авч үзжээ. Монгол хэл шинжлэлд эрдэмтэд, үнэлэмжийг "Монгол хэлний аялга үг өгүүлбэр нь холбосон орчны дотор өгүүлэгчээс тухайн юм үзэгдэл, орон цагт хандах хандлага, өгүүлэгчийн мэдрэхүйн олон янз шинж түүний илрэл, сэтгэлийн хөдөлгөөний өнгө, уриалах хөг аялга, баймж үнэлгээ зэргийг илэрхийлж харилцах түвшинд чухал үүрэг гүйцэтгэдэг." (Пүрэв-Очир, Гулиранз, 1993, х.7), "Монгол хэлний - хан (хэн, хон, хөн) бүтээвэр тэмдэг нэрийн утгыг бууруулах үүрэггүй бөгөөд харин өгүүлэгч этгээд тухайн шинж

чанарыг хэрхэн үнэлж байгаа сэтгэлийн өнгө аяс илтгэдэг байна. Жишээ нь: хархан нүд, цагаахан сэтгэл, борхон ботго, аятайхан санаа гэх мэт эдгээр жишээнээс үзвэл хар, бор, цагаан, аятай гэсэн тэмдэг нэрээр илэрч байгаа шинж чанар өгүүлэгчид таатай санагдсан сэтгэлийн аяс илэрч байна." (Өнөрбаян, 2004, х.236), "-дуу(-дүү), -втар (-втэр,-втор) нь үгсийн хоорондын харьцаа, орон цагийн харьцаа заахгүй, тухайн тэмдэг нэрээр илэрч байгаа шинж тэмдгийг өгүүлэгч этгээд тийм ч хангалттай бус гэж үзэж байгааг илэрхийлсэн утгын нэмэлт өнгийг оруулдаг байна. -дуу(-дүү), -втар (-втэр,-втор) морфемоор илэрч байгаа утгын өнгө нь өгүүлэгч этгээдийн хэлний хэрэгцээнд өртөж байгаа тухайн шинж чанарыг агуулсан юмны шинж тэмдгийн хэр хэмжээг өгүүлэгч этгээд хэрхэн үзэж байгааг харуулж байна. Энэ нь өгүүлэгч этгээд бодит байдалд хандаж байгаа хандлага харьцаа юм." (Бямбасан, 1975, х.69), "Аливаа хүн ертөнцийн юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг таньж мэдэх болгондоо түүнд ямар нэг үнэлэмж өгдөг нь зайлшгүй юм. Энэ үнэлэмж нь эерэг сөрөг гэсэн ерөнхий хоёр талтай байх боловч эерэг сөрөг тал бүр нь дотроо ашигтай-ашиггүй, зохистой-зохисгүй, таатай-таагүй гэх зэрэг дэд эсрэгцэлтэй байх болно." (Баянсан, 2016, х.98), "Үнэлэмжийн ай нь хэлний янз бүрийн түвшний олон хэрэглүүрээр илэрдэг утга зүйн

* ✉ munkhtuya_ba65@yahoo.com

нэлээд сонирхолтой ай бөгөөд үнэлэмжийн чанар агуулга нь эерэг ба сөрөг үнэлэмж, сайшаасан ба эс сайшаасан, зөвшөөрсөн ба эс зөвшөөрсөн, зэмлэсэн, гайхсан, эргэлзсэн, егөөдсөн зэрэг баймж утга байх бөгөөд эдгээр нь өгүүлэгчийн сэтгэлийн байдал, сэтгэлийн хөдөлгөөн, яруу илтгэх өнгө аясыг давхар илэрхийлсэн байж болно” (Мөнх-Амгалан, 1998, х.222) хэмээн бүтээвэр, үг, өгүүлбэр зэрэг хэлний нэгжийн утгатай холбон тайлбарласан уламжлал байна. Сүүлийн үеийн судалгаанд, ”Үнэлэмж гэдэг бол байгаль ертөнцийн болоод хүний амьдралын үй түмэн үзэгдлийн мөн чанар, тэдгээрийн цаг хугацаа-орон зайн дотор орших хувьсал өөрчлөлт зэрэгт өгүүлэгч этгээдээс өгч байгаа үнэлэлт дүгнэлт, хандлагыг адилтгал зүйрлэлийн дүнд илрүүлэх явдал юм.” (Цэрэнчимэд, 2010, х.138), “Өгүүлэгч этгээд өгүүлж буй зүйлээ сайшаасан, эс сайшаасан, зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн, буруушаасан, зэмлэсэн, гайхсан, эргэлзсэн, үл итгэсэн, егөөдсөн зэрэг янз бүрийн үнэлэмж, хандлагатайгаар илэрхийлсэн байдаг. Үүнийг эхийн нэмэлт санаа буюу баймж чанар гэж нэрлэнэ. Ийнхүү эхийн зорьсон санаа нь өгүүлэгчийн хандлага, баймж, үнэлэмжээс бүтдэг.” (Өнөрбаян, ба бус, 2007, х.19) хэмээснээс харахад, “үнэлэмж”-ийг адилтгах,

зүйрлэх ур маяг, эхийн санаа зэрэгтэй холбон авч үзжээ.

Дүрслэлт чимэг тодотгол нь “шууд бус нэрлэлт” бөгөөд танихуйн хэлшинжлэлд “метафор” гэсэн нэр томьёо, ухагдахууны дор судлах нь бас нэгэн шинэ чиглэл болж байна. Метафор нь хүний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгдэж байдаг төдийгүй, яруу найраг, уран зохиолын төрөл зүйлд хүртэл арвин баялаг орсон байдаг бөгөөд Р.Якобсоны хэлснээр ”Бүх үгэлбэр бол нэг бол метафорик нэг бол метонимик хэв шинжид хамаардаг” байна. Метафор бол тухайн ойлголт ухагдахуунд ард түмэн хэрхэн хандаж ирсэн түүхэн төсөөллүүдийг тусгадаг учраас концептыг тодорхойлон бичихэд онцгой учир холбогдолтой (Цог-Очир, 2015, х.95). Иймд, уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотгол ба үнэлэмжийн харьцааг танихуйн хэл шинжлэлийн метафорын загвараар тайлбарлавал, үүрэг хэрэглээ нь илүү тодорхой харагдана.

Уран сайхны эхийн найруулгад дүрслэлт чимэг тодотголоор илрэх өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг “байгаль ертөнц” гэсэн цогц ойлголт(концепц)-ын жишээн дээр авч үзвэл,

Хүснэгт I

“Эх орон, эх нутаг” -ийн дүрслэлт чимэг тодотгол ба өгүүлэгчийн үнэлэмж

Эх сурвалжийн хүрээ	Дүрслэн буулгалт - Метафор	Зорилгын хүрээ
Хүний орчлонгийн дээр оршиж, бүхнийг мэдэж захирах хүч, түүний орших орших орон-“тэнгэр” хэмээх итгэл үнэмшил	...Намайг элээгээд үлдэх тэнгэрийн заяат нутаг (Ш.С)	- Байгалийг дээдэлж, сүслэн залбирах зан заншлыг харуулсан.
	Цэнхэр тэнгэрийн эх орон Таныгаа хайрлахгүй юм бол Өөр юугаа хайрлах билээ, эх орон минь (Д.Ц)	
- Ариун амгалангийн орон, хүний аж төрөхөд аж тухтай нөхцөл бүрдсэн орчин газар, жаргалын орон “диваажин, үлгэрийн орон, бумбын орон” хэмээх үнэмшил	Тэмээний диваажин л гэж гэж тийм газар орон байдаг байх. (Д.Ц)	- Эх орноороо бахархан, хүндэтгэн дээдэлсэн өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн.
	Бумбын орон шиг нутгаа би Зүүдэлнэ чинээ бодсонгүй дээ хө. (Д.А)	
	...Эргэх улиралд өвс ус тэгш Энхжингийн орон цэнхэр номин хангай	
	...Үлгэрийн юм шиг тансагхан энэ нутаг Миний эх орон билээ. (Ш.Д) гэх мэт	

Нүүдлийн соёл иргэншилд байгалийг дээдэлж, анхдагчийн хэмжээнд өргөмжилж, шүтэн биширч, сүслэн залбирах сэтгэлгээ, зан заншил уламжилж ирсэн. Энэхүү чин эрхэмнэл,

дээд хүслэн нь өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн чимэг тодотголоор илэрдэг зүй тогтолтой байна.

Хүснэгт 2

“Уул, ус” -ны дүрслэлт чимэг тодотгол ба өгүүлэгчийн үнэлэмж

Эх сурвалжийн хүрээ	Дүрслэн буулгалт - Метафор	Зорилгын хүрээ
Сэтгэлээ ариусган, гэгээрэхийн дээд туйлд хүрэх итгэл үнэмшил	Нэрийг хэлдэггүй Сүсэгт уул минь (Б.Л) ...Халзан Бөхөнгийн Сүлдэн уул минь (Б.Л)	“Уул ус”-аа сүслэн, амь амьдралаа даатган залбирах үндэстний сэтгэлгээ, “уул ус”-аа дээдлэн шүтэх өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэсэн.
“Уул ус, байгаль дэлхий эзэнтэй” гэх амьдчилах сэтгэлгээ, итгэл үнэмшил	...Олон түмэн нь хүслээ даатгасан Орчлонд ганцхан хайрхан минь ...Мянган бурхны шившлэгтэй уул (Д.Ч) ...Цагаан бүхний дээжийг цогцлоож, цацлын есөн нүдээр дөрвөн зүг, найман зовхис руу шиврэн дусалсан монголын Цагаан уулс, Алтай минь. (Ж.Б)	
Эцэг,эхийн ач энэрэл	...Өлгийдөө сөгдсөн хүүгийнхээ Мэлмий нээдэг эцэг уул (Х.Л)	Эх нутгийн “уул ус” нь эцэг эхийн хайр энэрлийг үзүүлдэг гэх үндэстний сэтгэлгээ, “уул ус”-аа дээдлэн шүтэх өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэсэн.
	...Хүрэн жинст уул минь ёстой л, эр хүн шиг юм даа. Танд омгорхол, ихэрхэл, нулимст цэцэн уярал, инээмсэглэл бүгд байнам.(Д.Нямаа)	
	...Эхийн сүү шиг мөрөн голоо урсаж байдаг Монгол орон минь. (Ц.У)	
	...Ижий болсон цэнхэр нуураа Эргэж гурвантаа ганганах ч байсан юм бил үү ... (Б.Л)	

Дээрх жишээнээс харахад, уран сайхны эхийн найруулгын нэгэн зүйл тодотголд сав ертөнц, уул усаа сүслэн дээдэлж, хүсэл юугаан шивнэн даатгаж ирсэн өвөрмөц зан үйл, монгол соёл сэтгэлгээг илэрхийлсэн байх бөгөөд энэхүү концептэд эерэг үнэлэмж илрэх нь тодорхой юм.

Уран сайхны эхийн баримтаас үзэхэд, байгалийн өвөрмөц онцлог, түүнд хандах өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэсэн чимэг тодотголууд нь “тал”, “хангай”, “говь”, “хээр” тодотгуулагчтай байх нь олонтоо тохиолдож байна.

Хүснэгт 3

“Тал, хангай, говь, хээр” -ийн дүрслэлт чимэг тодотгол ба өгүүлэгчийн үнэлэмж

Эх сурвалжийн хүрээ	Дүрслэн буулгалт - Метафор	Зорилгын хүрээ
Тал, хээр, говь, хангай нутгийн өвөрмөц онцлог байдал	...Хөх туурь бол тэнгэрийн солир харван унаж байдаг, сар шөнөжингөө туулахдаа ч цуцдаг агуу уужим тал нутаг юм аа. (П.Б)	Эх нутгийнхаа байгалийн сайхныг магтан дуулсан, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн.
	...Гүйгүүл морин Зургаан сардаа тууламгүй Нүүгүүл үүлс Зуны сардаа барамгүй Тал минь, тавиухан цэнхэр тал минь. (Дан. Н)	
	...Сэвшээ хонгор салхитай Сэрүүн сайхан хангай ...(Д.Д)	
Сэтгэл санаа түвшин, тайван ахуй амьдрал	...Буурал эртний домог мөнхөд оршсон хаяа захгүй говьдоо ширээ хүрэн тэмээд тэнгэрээ өргөн тэшилдэж, цагаан зээрийн сүрэг цахилж нэг байж дэгдэх нь Дулаан Богд уул өөрөө хол замын биднийг дагаад ачаалах нь уу гэлтэй их говийнхоо энгэрээр өндөлзөнө. Ийм л сайхан өгөөмөр амгалан нутаг даа. (С.П)	

“Тал”, “хангай”, “говь” гэсэн тодотгуулагчийн чимэг тодотголууд нь их төлөв байгалийн өвөрмөц онцлогийг илтгэсэн эсвэл уудам дэлгэр, хязгааргүй орон зайн утга бүхий уран тодотгол байдаг нь

монголчууд ашдын заяат энэ уудам дэлгэр газар нутагтаа дөрвөн цагийн эргэлтэд нүүдэллэж ирсэн аж амьдрал, ахуй соёлтой холбоотой бөгөөд монголчуудын хувьд амьдралын тэнүүн чөлөөт

хэвшил, санаа сэтгэлийн уужим амгалан байдал зэрэгт онцгой ач холбогдол өгдөгтэй холбоотой юм.

Дүгнэлт

1. Эх орон, газар нутгийг шүтээн, тэнгэр, диваажин гэх мэтээр оюун сэтгэхүй, санааны агуулгатай дүрслэх ур маягаар тодотгож байгаа нь сүнсжүүлэн тэнгэржүүлэх эртний тэнгэр шүтлэг, үнэлэмж, хэлээр илэрч байгаагийн жишээ болохоос гадна байгаль ертөнц санаалаг, ариун гэж үздэг уламжлалт ойлголт монгол сэтгэлгээ одоо ч хүчтэй хадгалагддагийг харуулах монгол хэл, соёлын баримт юм.
2. Уран сайхны эхийн найруулгад сав ертөнц, уул усаа сүслэн дээдэлж, хүсэл юугаан шивнэн даатгаж ирсэн үндэстний зан үйл, соёл сэтгэлгээг илэрхийлсэн нэгэн зүйл тодотголууд түгээмэл байна. “Уул, ус” гэдэг нь монголчуудын хувьд ид шидийн орон зайн төв ойлголт болохыг харуулж байгаа бөгөөд энэхүү концептэд эерэг үнэлэмж илрэх нь тодорхой юм.
3. Байгалийн өвөрмөц онцлогийг илтгэсэн дүрслэлт чимэг тодотголууд нь уудам дэлгэр, хязгааргүй орон зайн утга бүхий эерэг үнэлэмжит уран тодотгол байдаг нь дөрвөн цагийн эргэлтэд нүүдэллэж ирсэн аж амьдрал, ахуй соёлтой монголчууд амьдралын тэнүүн чөлөөт хэвшил, санаа сэтгэлийн уужим амгалан байдал зэрэгт онцгой ач холбогдол өгдөгтэй холбоотой.

4. Дүрслэлт чимэг тодотголыг танихуйн хэл шинжлэлийн метафорын загвараар задлан тайлбарлаж, бодит ертөнцийг хэлээр сэтгэн ухаарч, дүрслэн буулгаж байгаа байдал, үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлог, өгүүлэгчийн үнэлэмжийн илэрхийлэл зэргийг илүү тодорхой нээн харуулах боломжтой юм.

Ашигласан материал

- Ахманова, О.С. (1966). Словарь лингвистических терминов. Москва
- Бямбасан, П. (1975). Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг. Улаанбаатар
- Баянсан, Ж. (2016). Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ. Улаанбаатар
- Мөнх- Амгалан, Ю. (1998). Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. Улаанбаатар
- Цог-Очир, А. (2015). Уур(хилэн) хэмээх ухагдахууны концептуал бүтэц. Лавай 12.
- Өнөрбаян, Ц. (2004). Орчин цагийн монгол хэлний үгзүй. Улаанбаатар
- Өнөрбаян, Ц. ба бус. (2007). Монгол хэл-7. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б., Гулираанз, З. (1993). Монгол хэлний өгүүлбэрзүйн судалгааны онол практикийн зарим асуудал. Улаанбаатар
- Цэрэнчимэд, Л. (2010). Уран сайхны эхэд илэрсэн харшууллын онцлог хэрэглээ. Улаанбаатар

Revelation of early characteristics of urban development (Examples of complex concepts “The Nature”)

B. Munkhtuya

Mongolian State University of Education Teacher's school in Arkhangai

Abstract

There is a possibility to explain narrator's judgment connecting with the role and usage of description mode and descriptive appositives in figurative text stylistics. Description mode is a very good attribute that has a role to figure the object of that description, and it is a language unit that includes the narrator's positive judgment, nations being, and special characteristics of culture and mindset.

There is an example of figurative text stylistics considering within the framework of the conception “the nature” as a whole unit. The narrator's positive judgment connected with the followings: mindset of adoring the nature in nomadic civilization, and praising, admiring, and worshiping it as the origin; traditional customs, veneration and desire; and the living, the being, and the culture living in nomadic life in the spacious area during four seasons of the year.

Key words

metaphor, the value of the speaker, epithet highlights